



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/236

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт  
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын нутаг дэвсгэрт байршилтай эзэмшил газрын газар эзэмшигч 3 иргэний гаргасан хүсэлтийн дагуу 0.2089га (2089м<sup>2</sup>) газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай



ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ  
ИРГЭДИЙН ЖАГСАЛТ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын ...-ны өдрийн  
А.З.Х. дугаар захирамжийн хавсралт

№	Иргэдийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Газар эзэмшүүлэх хугацаа	Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Ар тогоруутан овгийн Бадам Чулуу (РТ42100901)	6712008638	7-р баг Хийморь-4 441 тоот	24	Аймгийн Засаг даргын 2008.05.13-ны өдрийн №69 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтын 67 дахь хэсгийн 5 дахь заалтын талбайн хэмжээ "500м <sup>2</sup> " гэснийг "592м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх (мэдээллийн сан, бодит хэмжилт)
2	Гөрөөчин овгийн Гончиг Эрдэнэдаш (РЭ61020415)	6712012720	13-р баг 45-08 тоот	19	Аймгийн Засаг даргын 2011.04.20-ны өдрийн №44 дүгээр захирамжийн хавсралтын 77 дэх хэсгийн 6 дахь баганын талбайн хэмжээ "600м <sup>2</sup> " гэснийг "915м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх (хөрш нэгж талбартай харилцан тохиолцож хяналтын хэмжилтээр өөрчлөлт оруулсан, өөрийн хүсэлтээр)
3	Өндөрийнхөн овгийн Соргодог Батбилэг (РЭ83030834)	Шинээр (210705401 хуучин нэгж талбарын дугаар)	5-р баг Зах-9а тоот	19	Сумын Засаг даргын 2008.05.12-ны өдрийн №44 тоот захирамжийн холбогдох хэсгийн талбайн хэмжээ "775м <sup>2</sup> " гэснийг "582м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх (бодит хэмжилтээр)

*[Signature]*

000

Нийт талбайн хэмжээ-2089м<sup>2</sup>